

Цэргийн хөгжим нь эх оронч хүмүүжлийг төлөвшүүлж, монгол бахархлыг бадраана

Ш.Цогтгэрэл¹, Б.Бат-Өлзий¹

*¹Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Цэргийн
Хөгжмийн Политехник Коллеж*

Key words:

Patriotism, military
music, march,
resilience, soldier.

Abstract: Military music plays an important role in instilling patriotism and national pride in children and youth. The march, the main work of military music, is energetic, lively, majestic, cheerful, and with its beautiful melody, it can refresh the soul of any person, call for goodness, and influence patriotism and resilience.

Оршил

Аливаа улс оронд үндэсний бахархал болсон олон зүйл байдаг. Тухайлбал эх орон, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний уламжлал, түүх, соёл урлаг гэх мэт. Батлан хамгаалах салбарын салшгүй хэсэг болсон цэргийн хөгжим нь хүүхэд залуучууд, ард иргэдэд эх оронч үзэл, үндэсний бахархлыг төрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь цаашид ч олон зуу, олон мянган жил үнэ цэнээ алдахгүй үргэлжилнэ гэж харж байна. Учир нь төрт улс үүссэн тэр цагаас цэрэг арми байсан бол цэрэг арми байгаа цагт цэргийн хөгжим байх нь тодорхой юм. Монголчууд 2000 гаруй жилийн тэртээ буюу Хүннү гүрний үед төрт улсаа байгуулсан тухай түүхийг өнөөдөр бүгд мэддэг болсон.

Мөн тэр үед цэргийн хөгжимтэй байсан тухай мэдээллийг эрдэмтэн судлаачид сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдээс тодотгон өгүүлсэн баримт цөөнгүй байдаг. Тодруулбал, “НТӨ 100 дугаар онд холбогдох нэгэн хятад сурвалжид Хятадын Хан улсын цэргийн жанжин Су-Ү монголчуудад баригдан хоригдож байхдаа “...Шөнөдөө Хүннүгийн хөдөө хязгаарт суухад үргэлж Хүннү цэргийн бүрээний дуу миний чихээр ороод зүрхийг имчнээ”¹ гэж бичсэн байдаг. Энэ бол монголчууд бид 2000 гаруй жилийн өмнө цэргийн хөгжмийг ашиглаж байсны нотолгоо төдийгүй цэргийн хөгжмөөр хүний сэтгэл зүйд эрт дээр үеэс нөлөөлж ирсэн тухай баримт юм. Харин орчин үед, дэлхийн ихэнх улс орон “Цэргийн хөгжим”-ийг төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа, цэргийн жагсаал, цэргийн сургалт бэлтгэлд өргөнөөр ашиглаж байна.

Үндсэн хэсэг

“Дэлхийн улс үндэстнүүд олон зуун жилийн туршид дайн тулааны үед

¹ Сүхбаатар Г. Монголын эртний түүх судлал. I боть. УБ., 2000. т.135.

ч, тайван цагт ч “Цэргийн хөгжим”-ийг чухал хэрэглүүр болгон ашиглаж иржээ. Учир нь ерөөс урлаг хэмээх зүйл, түүний дотор хөгжмийн урлаг нь хүмүүсийн оюун сэтгэхүйд ихээхэн нөлөөтэй байдагтай холбоотой. Хөгжим нь хүнд оюун санаа, гоо сайхны өндөр хэмжээний сэрэл мэдрэхүй, таашаалыг төрүүлэхээс гадна шинжлэх ухааны нэгэн адил мэдлэг ухааныг ч өгч чаддаг хэрэглэгдэхүүн болой. Хөгжим ийнхүү хүмүүсийн оюун сэтгэхүйд хүчтэй нөлөөлж, хүний зүрх сэтгэлд гайхалтай мэдрэмжийг төрүүлэгч удвистай учраас цэргийн олон нэрт жанжид, авьяаслаг удирдагчид хөгжмийн ид шидийг ашиглаж, олон зууны туршид улс гүрнүүдийн доторх том, жижиг дайн тулаан, дэлхийн олон орныг хамарсан аугаа их байлдан дагуулалтын үед ч цэргийн хөгжмийг ашигласаар ирсэн”². Жишээ нь:

XIII зуунд эзэн Чингис хаан дайн тулааны үед цэргийн хөгжмийн хэрэглэж байсан тухай маш олон баримт байдаг. Түүний нэг нь Марко Пологийн тэмдэглэл дэх “Наяны тэрслэн хөдөлсөн” гэдэг хэсэгт “Тэд байлдааны их хэнгэрэг дуугарахаас нааш тулалдаанд ордоггүй бөгөөд энэ зуур бүгд хөгжимдөн дуулцгаадаг. Тэгээд хэнгэрэг дэлдэхэд хашгиралдан дайрна”³ хэмээн тэмдэглэжээ. Эндээс үзэхэд Чингис хааны цэрэг дайчид хөгжим эгшиглэхэд жагсаалаа тэгшитгэж, мөн хөгжмийн эгшгээр /байлдааны хэнгэрэг дэлдэхэд/ довтолгоонд орж байсан нь тодорхой байна.

XXI зууныг өнөөдөр мэдээлэл технологийн эрин зуун гэдэг ч энэ зуунд төрийн ёслол болон цэргийн жагсаалын хөгжмийг ямар ч улс оронд цахим хэлбэрээр эгшиглүүлдэггүй. Харин ч бүгд цэргийн хөгжмийг ёслол төгөлдөр эгшиглүүлж цэрэг армийнхаа сүр жавхааг илэрхийлдэг. Тэгэхээр цэргийн хөгжим нь аливаа улс үндэстэнд зайлшгүй байх шаардлагатай төдийгүй тухайн улсын сөрөн тэсвэрлэх чадавхад нөлөөлдөг болох нь харагдаж байна.

Монголчууд дэлхийг байлдан дагуулж байсан XIII зуунд цэргийн хөгжмийг “Цэргийн удирдлагын дуут дохиог өгөх болон цэргийн сэтгэл зүйд нөлөөлөх” гэсэн 2 том зорилгоор ашиглаж байсан. Үүнд:

1. Цэргийн удирдлагын дуут дохиог анх дайн байлдааныг эхлүүлэх, дуусгах, ухрах болон давших дохио өгөх, тарж бутарсан бүлэг, хэсгүүдэд цугларах газрыг нь заах зэрэгт.

2. Цэргийн хөгжмийн гол үүрэг нь дайчдын сэтгэл зүйд нөлөөлөх агуу их удвис, хүчинд дулдуйддаг бөгөөд цэрэг дайчдын сэтгэл зоригийг чангатгах, дайсныхаа зүрхийг мохоон айлгах, алс холын аян дайнд яваа дайчдын эх нутаг, элгэн саднаа санагалзсан сэтгэлийн чилээг тайлан тайвшруулах, хаад ноёд, баатар эрсийн байгуулсан гавьяа, цэргийн жагсаалын сүр жавхааг илтгэн харуулах, баяр ёслол, найрын сүр хүчийг нэмж, сэтгэлийн цэнгэл

² Ш.Цогтгэрэл. Монгол цэргийн хөгжим уламжлал, орчин үе. УБ., 2011. т.16

³ Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987. т.88

эдлүүлэх зорилготой⁴ байсан.

Одоо цагт эртний монголчуудын цэргийн удирдлагын дуут дохионы хэлбэр нь төдийлөн өөрчлөгдөөгүй гэж үзэж байна. Тодруулбал, “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд”-д бүрээгээр өгөх дохио, бөмбөрийн цохилтуудыг тодорхойлж өгснөөс гадна “өглөөний босолт, хичээлээ эхэл, хоолондоо, жагс, туяа, төгсгөл, анхаар, цуглар, захирагч нар цуглар, гал нээ, түгшүүр, харуулд алхаад-марш зэрэг бүрээгээр өгөх дохионы аялгуу болон “тугийн дор, харуулд алхаад-марш, аяны марш №1, аяны марш №2, түгшүүр”⁵ зэрэг бөмбөрчний цохилтуудыг хөгжмийн эгшиглээсээр /ноот/ тэмдэглэж өгсөн байдаг. Энэ нь дохио дуудлагын хэлбэр байсаар байгаагийн нотолгоо бөгөөд баяр ёслол, гашуудал болон янз бүрийн хүндэтгэлийн арга хэмжээнд цэргийн хөгжим үүрэг гүйцэтгэсээр байна.

Монголчууд цэргийн сэтгэл зүйд нөлөөлөх зорилгоор цэргийн хөгжмийг ашиглаж ирсэн түүхэн баримт ч нэлээдгүй байна. Тэдгээрийн нэгийг доорх зургаас харж болно.



Зураг 1

Их Монгол улсын байлдан дагуулалтын тухай харуулсан энэхүү түүхэн зурагт Багдадын хэрэм рүү дайрах монголчуудын довтолгоог дүрсэлсэн бөгөөд эхний эгнээнд харваачид, дараагийн эгнээнд дайны хэнгэргийг нэг нь оосорлон барьж, нөгөө нь цохиураар цохиж буй хөгжимчдийг, түүний ард морь унасан цэргийн жанжныг “Хар сүлд”-ийн хамт дүрслэн үзүүлжээ⁶.

Энэ нь дайн тулааны үед цэргийн хөгжим нь цэргийн жанжны хамт

⁴ Ш.Цогтгэрэл. Монгол цэргийн хөгжим уламжлал, орчин үе. УБ., 2011. т.71


⁵ Ш.Цогтгэрэл. Монгол цэргийн хөгжим уламжлал, орчин үе. УБ., 2011. т.71

⁶ Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд. УБ., 2022. Х-168-171

тэргүүн эгнээнд байж, чухал үүрэг гүйцэтгэж ирснийг тодотгож өгснөөс гадна тулалдааны үед өөрсдийн цэргүүдийн зоригийг чангатгах, дайсны цэргүүдийн зоригийг мохоох зорилгоор хэнгэрэг, цан дэлдэж чанга, сүрлэг дуу чимээ үүсгэж сэтгэл зүйд нь нөлөөлж байсны нэгэн баталгаа юм.

Өнөө үед ч цэргийн хөгжмөөр цэрэг дайчдын сэтгэл зүйд нөлөөлсөөр байна. Үүнийг доорх судалгаанаас харж болно. Судалгаанд 400 гаруй хүн хамрагдсан бөгөөд “Цэргийн үлээвэр найрал хөгжмөөр маршийн аялгуу сонссоноор таны сэтгэл зүйд ямар өөрчлөлт гардаг вэ” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 96 хувь нь “Эрч хүч, урам зориг өгдөг, цэрэг армиар бахархах сэтгэл төрдөг” гэж хариулсан байна.

1 дүгээр график. “Цэргийн үлээвэр найрал хөгжмөөр маршийн аялгуу сонссоноор таны сэтгэл зүйд ямар өөрчлөлт гардаг вэ” гэх асуултад



a. Эрч хүч, урам зориг өгдөг

b. Цэрэг армиар бахархах сэтгэл төрдөг

c. Ямар ч өөрчлөлт гардаггүй

Тэгэхээр цэргийн хөгжмийн нөлөө, ялангуяа сэтгэл зүйд нь бахархал төрүүлж урам зориг, эрч хүчийг бий болгох удвис нь асар их гэдэг нь тодорхой юм. Эндээс аль ч цаг үед цэргийн хөгжмийн үнэ цэнэ, ач холбогдол, үүрэг хариуцлага өндөр байгааг харагдаж байна.

Цэргийн хөгжмийн гол уран бүтээл бол “Марш” билээ. Өнөө цагт цэргийн хөгжмийг “Марш”-ийн бүтээлгүйгээр төсөөлөх аргагүй юм. Тиймээс марш хэмээх энэ гайхалтай хөгжмийн бүтээлийн түүх, утга учир, үнэ цэнийг тодотгоё.

Францаар “Marcne” гэдэг үг нь “явах, явалт” гэсэн утгатай. Харин оросын хөгжмийн нэвтэрхий тольд марш гэдэг үгийг “Гэрэлт жагсаал, урагшлах хөдөлгөөн”⁷ гэсэн утгаар тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл энэ

⁷ Большой энциклопедический словарь Музыка. 1998. Стр.328

нь олон тооны хүмүүсийн урагш тэмүүлэх хөдөлгөөн гэж ойлгож болох юм.

Маршийг анх XVII зуунд Францын хөгжмийн зохиолч Жан Батист Люлли бичсэн ⁸ байна. Харин монголчууд 1930-аад оны эхэн үеэс энэ бүтээлтэй танилцсан байдаг. Маршийн уран бүтээл нь үлээвэр найрал хөгжмийн урын сангийн үндэс болдог. Дэлхийн ихэнх улсад үлээвэр хөгжмийн зэмсгүүдээс бүрдсэн найрал хөгжмийг “цэргийн хөгжим” гэж нэрлэн төрийн болон цэргийн ёслолын үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд маршийн аялгуугүйгээр цэргийн хөгжмийг төсөөлөх аргагүй юм.

Маршийн бүтээл нь дайчин цоглог шинжийг илүү агуулсан байдаг. Маршийн бүтээлээр цэрэг, дайчдын цог жавхаа, тэдний үйл ажиллагааны онцлогийг тодотгох төдийгүй нийт ард түмэн, залуу үеийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж тэднийг сайн сайхан, гэрэлт ирээдүйд нэгтгэн, ялалтаас ялалтад урайлан дуудаж, нэгэн санаа зорилгод нэгтгэж бас зоригжуулж чаддаг хүний оюун санааны гайхамшигтай бүтээл юм.

Марш хэмээх хөгжмийн бүтээл нь эрчимт хэмнэл, алхахад зохицсон тодорхой хэмжээтэй бичигдсэн аязууд байдаг. Гэхдээ түүний шинж төрх, хэв маяг нь нэг л зүйлийг илэрхийлэх буюу хэмжээ нь үргэлж 2 юм уу 4 хувь /доль/ байна. Энэ төрлийн хөгжмийн бүтээл нь агуулгын хувьд ихэвчлэн зоригтой, идэвхтэй, жавхаатай, цоглог, хөгжилтэй шинж төрхийг илэрхийлнэ. Тэгэхээр маршийн зохиол нь ихэвчлэн сэтгэл сэргэм яруу аялгуутай, хөл жигдрүүлсэн цоглог хэмнэлтэй байдаг. Хэдийгээр маршийн зохиол нь хоорондоо аялгуугаараа ялгагддаг ч жагсаалын, аян замын, баярын, гашуудлын, концертын гэх мэт сэдэв, агуулгын хувьд янз бүр байдаг. Тодруулбал, жагсаалын марш нь цэргийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээний үед эгшиглэдэг цэргийн нэгдэл сүр хүчийг илэрхийлсэн аялгуутай бол дохионы марш нь яг ямар шалтгаанаар цэргүүдийг дуудаж байгааг тодорхойлж өгдөг. Харин гашуудлын марш нь удаан хэмнэлтэй марш бөгөөд хүний сэтгэл зүйн эргэлзээ, бодол санаа, түр зуурын сэтгэл хямрал, сэтгэлийн эмзэглэл зэргийг аялгуугаар бий болгох мөн тайтгаруулах үүрэгтэй.

XX зууны эхэн үеийн монголын нийгмийн тогтолцооны өөрчлөлтүүд нь нийт ард түмний ухамсар, хандлага, сэтгэлгээнд нөлөөлж улмаар Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, Ардын хувьсгалын үеэр өөрсдөө дууны үг зохиож, өөрсдийн сайн мэддэг ардын дууны аялгууг маршийн хэмнэлд оруулан дуулж байсан баримтууд олон бий. Тодруулбал, 1930-аад он хүртэл Шивээ Хиагт, Магнаг үсэгтэй туг, Улаан туг, Баатар вангийн цэргүүд... гэх мэт дуунуудыг партизан цэргүүд болон ардын журамт цэргүүд эрч хүчтэй, цоглог хэмнэлд оруулан явган жагсаалаар алхахдаа төдийгүй морьт цэргийн жагсаалын үеэр ч дуулдаг байсан. Харин 1933 онд Бүх улаан цэргийн

⁸ К.Розеншильд. Гадаадын хөгжмийн түүх. 2006. I боть. т.101.

хөгжмийн капельмейстр Т.Балданцэрэн “Улаан наран” хэмээх дуу зохиож морьт цэргийн марш болгосон нь монгол хүний зохиосон анхны марш төдийгүй морьтон монгол цэргүүдийн цог хийморийг сэргээж байжээ.

Дэлхийн II дайны жилүүдэд монголын радиогоор нийт ард түмэн, цэрэг дайчдынхаа сэтгэл санааг өргөх зорилгоор цэргийн найрал хөгжмийн тоглолтыг /концертыг/ өргөн нэвтрүүлдэг байсан. Тэр үеийн цэргийн найрал хөгжмийн тоглолтын хөтөлбөрт хамгийн гол нь цэргийн маршийн аялгууг голлодог байжээ. Мөн “1941-1945 оны дайны жилүүдэд орост А.В.Александров-ын “Ариун дайн” /Священная война/ хэмээх марш хэмнэлтэй дуу оросын цэргийн хөгжмийн бэлгэ тэмдэг болон эгшиглэхийн зэрэгцээ орос цэргүүдийг ирээдүйн сайн сайханд тэмүүлэх итгэл, эр зоригийн дуудлага болон цуурайтсан”¹⁰ гэж бичжээ. Дээрх баримт, мэдээллүүдээс харахад зөвхөн монголчууд төдийгүй дэлхийн бусад улс оронд ч цэрэг эрсийг зоригжуулах, сэтгэл санааг нь өргөх зорилгоор марш хэмнэлтэй дууг өргөнөөр ашиглаж байсан нь харагдаж байна. Энэ нь дайн тулааны үед цэрэг эрсийн сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлж байсан нь тодорхой юм.

Мөн XX зууны дунд үеэс монголын хөгжмийн зохиолчид марш хэмнэлтэй дууг олноор зохиож байсан. Жишээ нь, “Түүхт хил”, “Торгон хилийн зүг”, “Дайчин нөхдийн тухай дуу”, “Манай цэргийн жавхаа”, “Эгэл цэрэг” зэрэг дуунуудыг жагсаалын алхаагаа тэгшитгэн дуулж үзээгүй офицер, ахлагч, сонсогч, байлдагч ховор биз ээ.


Тиймээс ч хүүхэд залуучуудад энэ хөгжмийн бүтээлээр дамжуулан эх оронч үзлийг төлөвшүүлэх нь зүйтэй гэж харж байна. Энэ нь бидний авсан судалгаагаар ч нотлогдсон.

Цэргийн албан хаагчид болон энгийн ажилтан, албан хаагчид оролцсон 200 гаруй хүнийг хамруулан “Та маршийн аялгууг ямар онцлогтой гэж боддог вэ” гэсэн асуултаар судалгаа авахад 88 хувь нь “Цоглог, эрч хүчтэй хэмнэл, урам зориг өгөх аялгуу нь эх оронч сэтгэлгээг төлөвшүүлж, эв нэгдлийг бэхжүүлэн хүний сэтгэл санааг өндөрт өргөдөг” гэж хариулснаас харахад ч эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлэх нь харагдаж байна.

⁹ Большой энциклопедический словарь. Москва 1998. Стр-24. Александров.А.В. /1883-1946/. Зөвлөлтийн хөгжмийн зохиолч, удирдаач, багш. Зөвлөлтийн армийн дуу бүжгийн чуулгыг үндэслэгч, тус чуулгын удирдаач. Мөн Зөвлөлт Холбоот Улсын сүлд дуулалын хөгжмийг зохиосон

¹⁰ Ш.Цогтгэрэл. Монгол цэргийн хөгжим уламжлал, орчин үе. УБ., 2011. т.24

2 дугаар график. Та маршийн аялгууг ямар онцлогтой гэж боддог вэ?



а. Цоглог, эрч хүчтэй хэмнэл, урам зориг өгөх аялгуу нь эх оронч сэтгэлгээг төлөвшүүлж, эв нэгдлийг бэхжүүлэн сэтгэл санааг өндөрт өргөдөг

б. Зөвхөн цэргийн жагсаалд ашигладаг

в. Мэдэхгүй

г. Бусад хөгжмийн төрлүүдээс ялгардаггүй

Мөн Цэргийн хөгжмийн гол уран бүтээл болох марш нь анх XVII зуунд зохиогдсон ч өнөөдрийг хүртэл эгшиглэж байгаа нь аливаа улс орны Батлан хамгаалах салбарын үйл ажиллагааны үнэ цэнэ, цэргийн хөгжмийн үнэ цэнэ, маршийн уран бүтээлийн үнэ цэнийг тодотгож өгч байна. Тиймээс “Цэргийн хөгжим”-өөр дамжуулан эх оронч үзэл, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэх, улмаар цэргийн хөгжимд эгшиглэх маршийн аялгуугаар нийт ард түмний эв нэгдлийг бэхжүүлж, хүмүүсийг нэгэн зорилгын төлөө нэгтгэх боломжтой гэж харж байна.

Монголын цэргийн хөгжим нь 2000 гаруй жилийн тэртээ Хүннү гүрний үед байсан гэдгийг түүхэн баримтуудаас бид үзлээ. Харин цаашид бид энэ салбараа хэрхэн хөгжүүлэх вэ. Сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчинд хөгжмийн салаатай анги, байгууллагуудын тоо цөөрч, улмаар хөгжимчдийн орон тоо дутагдалтай байгаа тухай ихээр яригдах болсон. Мөн МУ-ын ерөнхийлөгч ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн орон тооны нөхөн хангалтыг гүйцээх үүрэг өгсөн ч хэрэгжүүлж чадахгүй байгааг бид бүгд мэднэ.

Тиймээс бид үлээвэр найрал хөгжимтэй ангиудын тайван цагийн орон тооны нөхөн хангалтын байдалд дүн шинжилгээ хийж үзсэн. Манай Зэвсэгт хүчинд үлээвэр найрал хөгжимтэй 22 нэгтгэл, анги байдаг бөгөөд энд нийт 360 хөгжимчин байх ёстойгоос одоогийн байдлаар 181 хөгжимчин ажиллаж, орон тоо, нөхөн хангалт нь 50,2 хувьтай байгаа нь хүний нөөцийн дутагдалд орсныг харуулахын зэрэгцээ үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг

дээшлүүлэхэд сөргөөр нөлөөлж болох талтай. Тэгэхээр Монголын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүний салшгүй нэг хэсэг болсон “Цэргийн хөгжмийнхөн” рүү чиглэсэн, энэ салбарыг хөгжүүлэх дорвитой бодлого, шинэчлэл хийх нь зүйтэй болов уу.

Эцэст нь хэлэхэд маршийн бүтээл нь зөвхөн цэрэг, армийн хэрэгцээнд бус нийт ард түмний эх оронч үзлийн төлөвшилд гүнзгий нөлөөлөх боломжтой хөгжмийн зохиолын нэгэн чухал төрөл бөгөөд хүүхэд, залуучууд, ард иргэдэд эх орноо хайрлан хамгаалах, тэдний эх оронч үзлийг төлөвшүүлэх, үндэсний бахархлыг төрүүлэхэд цэргийн хөгжим чухал үүрэгтэй гэж үзэж байна. Учир нь цэргийн хөгжмөөр эрч хүч, урам зориг, эв нэгдэл, бахархлыг төрүүлэх боломжтойгоос гадна аливаа саад бэрхшээлийг даван туулах үеийн сөрөн тэсвэрлэх чадавхыг ч нэмэгдүүлж болно.

Ингээд эцэст нь Францын удирдагч Наполеон Бонапартын “Оростой байлдахад манай цэргүүдэд хоёр л том дайсан байсан. Нэг нь Оросын хүйтэн өвөл, нөгөө нь оросын цэргийн хөгжим”¹¹ гэж хэлсэн үг, мөн Оросын цэргийн гарамгай жанжин А.В.Суворовын “Би Измайлыг”¹² чанга сүрлэг дуутай хөгжим, намирсан тугтай эзлэн авч байсан. Цэргийн хөгжим нь армийн сүр хүчийг 2-3 дахин нэмдэг”¹³ гэсэн эшлэлүүдээр энэхүү өгүүллээ өндөрлөе.

Эшлэл авсан эх сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт

1. К.Розеншильд. Гадаадын хөгжмийн түүх. I дэвтэр. УБ., 2006
2. Ш.Цогтгэрэл монгол цэргийн хөгжим уламжлал орчин үе. УБ., 2011
3. Ш.Цогтгэрэл. Хөгжмийн төрөл хэлбэр ба хөгжмийн зохиолын нэр томъёоны тайлбар. УБ., 2019
4. Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд. УБ., 2022
5. ЗХЖШ-ын Цэргийн хөгжмийн албаны дүрэм. УБ., 2018
6. Большой энциклопедический словарь Музыка. Москва., 1998
7. Сүхбаатар Г. Монголын эртний түүх судлал. I боть. УБ., 2000
8. “Аюулгүй байдал, Батлан хамгаалах судлал” сэтгүүл. 2023
9. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987

¹¹ Ш.Цогтгэрэл. Монгол цэргийн хөгжим уламжлал, орчин үе. УБ., 2011. т.17

¹² Украин улсын Одесса мужид харъяалагдах хот.

¹³ Ш.Цогтгэрэл. Монгол цэргийн хөгжим уламжлал, орчин үе. УБ., 2011. т.17